



“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК



ЦАХИМ ТАНИЛЦУУЛГА

Монголын цахилгаан холбоо ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээний цахим брошуртай танилцаж өрхийн болон албан байгууллагад зориулсан үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг аваарай.





МОНГОЛЫН
ЦАХИЛГААН
ХОЛБОО ХК

ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МАТЕРИАЛ | 2026

ХУРЛЫН ТОВ:

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн хурлын зааланд хуралдана.

Хаяг:

2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр

ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

1.Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай, Үүнд:

- 1.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
 - 1.3. Ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай
 - 1.4. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай
 - 1.5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах тухай
- 2.Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай
- 3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
- 4.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;

ХУРЛЫН МАТЕРИАЛТАЙ 2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРӨӨС ЭХЛЭН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ.

Хурал зохион байгуулах комисс:

Комиссын дарга: Ч.Цогтгэрэл

Гишүүд: Х.Цэцэгмаа, Г.Батнасан

Утас: 7010 2210, 7010 2266

И-мэйл:otgonchimreg@mtcone.net, azlawyer@mtcone.net ,ch.tsogtgerel@mtcone.net

Тооллогын комисс:

Комиссын дарга: Т.Бямбасүрэн

Гишүүд: Б.Дагвадорж, Э.Булганчимэг

Утас: 7010 2211, 7010 2305

И-мэйл:planning@mtcone.net, bulganchimeg@mtcone.net, dagvadorj@mtcone.net

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхнийхээ амрыг эрэн мэндчилж 2025 онд хийсэн үйл ажиллагааны үр дүн, 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн гол зорилтуудаа танилцуулж байна.

2025 онд 8 аймгийн 9 сумдад өндөр хурдны интернэт үйлчилгээг шилэн кабелиар хүргэх төслийн хүрээнд 64 км магистраль кабель татан үндсэн сүлжээг өргөтгөн, Wi-Fi 6 шинэ технологийн туршилт хийж 3 аймгийн 3 суманд нэвтрүүлч хэрэглэгчийн сүлжээг өргөтгөсөн. FTTH төслийн хүрээнд нийт 21 аймаг, 86 суманд гуравласан үйлчилгээг хүргэж хэрэглэгчийн тоогоо өмнөх оноос 2 дахин нэмэгдүүллээ.

Интернэтийн ачаалал, сүлжээний ажиллагааг сайжруулах хүрээнд Windows Update, Office365, OneDrive, Teams үйлчилгээг кэшлэн, DO сервер болон дотоод CDN чиглүүлэлт нэвтрүүлэн гадаад гарцын урсгалыг бууруулан өртөг хэмнэн ажиллалаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад 280 ажилтан, өндрийн аюулгүй ажиллагааны сургалтад 49 ажилтан, анхны тусламжийн сургалтад 158 ажилтан, “Галын аюулгүй байдлын сургалт”-г онол, дадлага хослуулан зохион байгуулж, инженер техникийн ажилчдын хөдөлмөр хамгааллын

ажлын онцлогт тохирсон стандартын хөдөлмөр хамгааллын хувцсаар бүрэн хангалаа.

2025 оны 4-р сард нийт ажиллагсдын үндсэн цалинг 15-20 хүртэл хувиар нэмэгдүүллээ. Компанийн хэмжээнд хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, мэргэжлийн мэдлэг, ажлын бүтээмж дээшлүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллага болон МТС академитай хамтран 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 600 гаруй ажилтан танхимаар болон цахимаар хамрагдсан байна.

Компанийн ашигт ажиллагааг сайжруулахад тогтмол анхаарч ажилласны үр дүнд 2021 оноос 5 жил дараалан цэвэр ашгийн түвшин эерэг үзүүлэлттэй гарлаа.

2026 онд бид гуравласан үйлчилгээний хэрэглэгчийн тоог 16,000-д хүргэх, хэрэглэгчийн сүлжээг шинэчилж, ADSL технологийг халах, TV Room контентийн санг баяжуулах, SIP application нэвтрүүлэх зэрэг томоохон ажлууд эхлүүлээд байна.

Харилцаа холбооны салбарт технологийн шинэчлэлт эрчимтэй явагдаж байгаа өнөө үед энэхүү хөгжлөөс хоцролгүй үндсэн суурь дэд бүтэц, сүлжээний аюулгүй байдлыг тодорхойлон ISO/IEC 27001:2022 менежмент тогтолцоо нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Цаашид бид шинэ техник технологи үйлчилгээнд нэвтрүүлж, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж, ажиллагсдыг чадавхжуулан бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулан, компанийн ашигт ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн өгөөж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхээр хичээн ажиллах болно.

ХҮНДЭТГЭСЭН

МОНГОЛЫН ЦАХИЛГАА ХОЛБОО ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЧИНБАТ

АГУУЛГА

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол-3
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд-7
3. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан-17
4. 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараасан тайлан-21
5. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт-22
6. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт-31
7. 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол-36
8. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны тогтоол, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, нэр дэвшигчдийн мэдээлэл-41
9. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн төсөл-50
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл-51
11. Саналын хуудасны загвар-53





**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
220 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 3 сарын 19 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, “Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрэм”-ийн 7.3, 7.4, 7.8.6, 7.8.7, 7.11, 7.19.9 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн хурлын зааланд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

2.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх

Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баглах тухай, Үүнд:

2.1.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай

2.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай

2.1.3. Ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай

2.1.4. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай

2.1.5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах тухай

2.2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай

2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;

2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр байхаар тогтсугай.

4. 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс өдөр тутмын сонин, телевиз, компанийн болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, зарыг 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр анх нийтэд мэдээлсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээллэхийг хурал зохион байгуулах комисс (Ч.Цогтгэрэл)-т даалгасугай.

5. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудасны агуулга, загвар”-ыг 3 дугаар хавсралтаар, “ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох саналын хуудасны агуулга,

2

загвар"-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, компанийн хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн төв байранд болон цахим хэлбэр (www.telecommongolia.mn)-ээр танилцах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Цэцэгмаа)-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдээс харьяалагдах брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилсан санал авах сүүлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10:30 цаг байхаар тогтсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Дотоод аудитын газрын захирал Г.Болдсайханыг томилсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Инновац, бизнес хөгжлийн газрын Бодлого, төлөвлөлтийн албаны ерөнхий менежер Т.Бямбасүрэн, гишүүдээр Удирдлага, хүний нөөцийн газрын Хууль, гадаад харилцааны албаны хуулийн мэргэжилтэн Б.Дагвадорж, Инновац, бизнес хөгжлийн газрын төлөвлөлтийн мэргэжилтэн Э.Булганчимэг нарыг тус тус томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Удирдлага, хүний нөөцийн газрын захирал Ч.Цогтгэрэл, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа, Удирдлага, хүний нөөцийн газрын мэргэжилтэн Г.Батнасан нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Ч.Цогтгэрэл)-г үүрэг болгосугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг компанийн батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
220 дугаар хурлын 02 дугаар тогтоолын Нэсдүгээр хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1.	Хурлын ирцийг бүртгэх (Тооллогын комисс)	
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын комисс)	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хэлэлцүүлэх	80 минут
	1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай. Үүнд: 1.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай 1.3. Ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай 1.4. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай 1.5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах тухай	
	2. Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай	
	3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;	
	4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;	
5.	Асуулт хариулт, санал	30 минут
6.	Санал хураалт	5 минут
7.	Хурлын завсарлага, тооллогын комисс санал хураалтын дүнг гаргах	15 минут
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10.	Хурлыг хаах (Хурлын дарга)	5 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
220 дугаар хурлын 02 дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралт

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ БОЛОН ГАРГАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ,
ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**



1. Компанийн 2025 оны жилийн тайлан
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
3. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
4. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин,
5. 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараасан тайлан
6. 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоол
7. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
8. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны тогтоол, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, нэр дэвшигчдийн мэдээлэл,
9. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийн төсөл

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Монголын цахилгаан холбоо ХК нь Улаанбаатар хот болон орон нутагт улс, хот хоорондын цахилгаан холбоо, интернэт, олон суваг дамжуулах үйлчилгээ, мэдээллийн лавлах, телекамерын үйлчилгээг үзүүлж байна. Улаанбаатар хотын төв байранд 6 газар, 11 алба, 1 охин компани, 21 аймгийн төв болон 290 сумдад, нийт 575 ажилтан албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2025 ОНД ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХЭЭР ХИЙСЭН ОНЦЛОХ АЖИЛ:

1. Үндэсний Статистикийн Хороонд “Хүн ам, орон сууцны тооллого – 2025” судалгааны дуудлагын төвийн систем байгуулан цогц үйлчилгээ хүргэлээ.



2. Гуравласан үйлчилгээний чанарыг сайжруулж, Wi-Fi 6 технологиор Архангай аймгийн Цэнхэр, Хэнтийн аймгийн Жаргалтхаан, Булган Сэлэнгэ сумдад үйлчилгээ нэвтрүүлэн цэгийн тоог 200-гаар нэмэгдүүллээ.

3. 2025 онд 8 аймгийн 9 сумдад өндөр хурдны интернэт үйлчилгээг шилэн кабелиар хүргэх төслийг хэрэгжүүлж 64.0 км магистраль кабелийг суурилуулж цэгийн тоог 650-иар нэмэгдүүллээ.





4. Интернетийн ачаалал, сүлжээний ажиллагааг сайжруулах чиглэлээр Windows Update, Office365, OneDrive, Teams үйлчилгээг кэшлэн, DO сервер болон дотоод CDN чиглүүлэлт нэвтрүүлэн гадаад гарцын ачааллыг 1GBps-ээр буурууллаа.

5. FTTH төслийн хүрээнд орон нутгийн гуравласан үйлчилгээний хэрэглэгч 2 дахин нэмсэн.



6. 26***** дугаарлалтын үйлчилгээ үзүүлэх ХХЗХ-с олгосон 2025 оны 161 тоот тусгай зөвшөөрлийн дагуу ТЕГ-тай гэрээ байгуулж, бусад оператортай харилцан холболтын гэрээ хийхээр ажиллаж байна.



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

7. Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа аймаг дүүргийн цагдаагийн газрын нийт 23 ш, 102 дугаарыг Коллцентр үйлчилгээнд бүрэн шилжүүллээ.





8. ЦХИХХЯ-с зохион байгуулсан, “Зүүн болон Хойд бүсийн харилцаа, холбоо, мэдээллийн технологийн чуулганд” хамтран оролцлоо.



ХАРИЛЦАА ХОЛБОО,
**МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН**

**ЗҮҮН
БҮСИЙН** **ЧУУЛГАН** 20
25

9. ЦХИХХЯ, ТЦҮЗГ-тай хамтран 21 аймагт TECHWEEK-2025 ICT форум “Харилцаа холбооны салбарын цаашдын чиг хандлага” хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулж оролцлоо.



10. ХХЗХ-оос “Харилцаа холбооны хөгжил 2025” баруун аймгуудын харилцаа холбооны салбарын чиг хандлага, тулгамдаж буй асуудлаар зөвлөгөөн зохион байгуулж, Улаанбаатар, Завхан, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын Холбооны газрын төлөөлөл оролцож, орон нутагт тулгамдаж буй асуудлаар илтгэл тавьж, ХХЗХ-д санал хүргүүлэн ажиллалаа.

11. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад 280 ажилтан, өндрийн аюулгүй ажиллагааны сургалтад 49 ажилтан, анхны тусламжийн сургалтад 158 ажилтан, Галын аюулгүй байдлын сургалтыг онол, дадлага хослуулан зохион байгуулсан. Сургалтуудад хамрагдсан ажилчдаас шалгалт авч, үр дүнг баталгаажууллаа. Компанийн хувьд 2025 он Үйлдвэрлэлийн осолгүй жил байлаа.



12. Эрсдэлтэй ажлын байранд ажил гүйцэтгэдэг 200 ажиллагсдыг гэнэтийн ослын даатгалд хамруулан, 120 ажилтныг эрүүл мэндийн тусгай багцын үзлэгт хамрууллаа.

13. Ажилчдыг тухайн ажлын онцлогт тохирсон стандартын шаардлага хангасан нэг бүрийн хувийн хамгаалах хэрэгслээр хангаж, зуны 117 хувцас, өвлийн 116 хувцсыг олгосон байна.



КОМПАНИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ



1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж Баянзүрх дүүргийн 28 дугаар хороонд шинээр байгуулагдаж буй IGM буюу Олон улсын Экологийн цэцэрлэгт хүрээлэнд 100 мод тарьж, хувь нэмрээ орууллаа.

2. “Цусаа бэлэглэж – Амьдралыг тэтгэе!” сайн үйлсийн донорын аяныг 15 дахь жилдээ зохион байгууллаа.



3. Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны зардлаар 60 ажилтныг хоёр удаагийн давтамжтайгаар Манжуур-Хайлаарын аялалд хамруулж урамшууллаа.



4. 1,366 ахмад холбоочдод 89.4 сая төгрөгийн урамшуулал, 39 ахмадад 5.4 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгож, сар шинэ болон ахмадын баяраар ахмад холбоочиддоо хүндэтгэл үзүүлэн хүлээн авч, ХХМТ-ийн салбарын спортын наадамд ахмад холбоочид амжилт дүүрэн оролцож дартсын төрөлд ахмад холбоочин З.Оюун хүрэл медаль, шатрын төрөлд ахмад тамирчин Ж.Цагаан алтан медаль, Д.Даваажаргал хүрэл медаль тус тус авч амжилттай оролцлоо.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

СУУРИН УТАС


Суурин утас нь орчин үед албан харилцааны чухал хэрэгсэл, бизнесийн соёл төдийгүй суурин утасны дугаар нь тухайн байгууллагын байр суурь, үйл ажиллагааны тогтвортой байдал, үнэ цэнийг илэрхийлдэг.

Та өөрийн бизнестээ харилцаа холбооны анхдагч оператор компанийн үнэ цэнтэй дугаарыг ашигласнаар харилцагчдадаа итгэл төрүүлж, бизнесийн нэр хүндээ өсгөх боломжтой.



ГУРАВЛАСАН БАГЦ

Бид орчин үеийн бизнесийн хурд, шаардлагад бүрэн нийцэх суурин утас, дата хязгааргүй өндөр хурдны интернэт, дуу, дүрсний өндөр чанар телевизийн олон суваг (IPTV-ийн хөгжлийн дараагийн OTT технологи ашигладаг) зэргийг нэгтгэсэн гуравласан үйлчилгээг санал болгож байна. Энэхүү технологийн дэвшилтэт шийдэл нь танай байгууллагыг 24/7 найдвартай, тасралтгүй холбоогоор хангана.



ХОСОЛСОН БАГЦ

Интернэт болон суурин утас нь албан байгууллага ажил хэргээ хөтлөн явуулах өдөр тутмын салшгүй хэрэглээ болсон. Иймд эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, сүлжээндээ үнэгүй ярих боломжтой суурин утас, дата хязгааргүй интернэтийн үйлчилгээг хослуулан, өөрийн хэрэглээндээ тохируулан авах олон сонголттой, хосолсон багцуудыг хэрэглэгч танд санал болгож байна.



БОДИТ ХУРДНЫ ИНТЕРНЭТ

Интернэт үйлчилгээг хуваагдсан (shared) болон бодит (dedicated) хурдаар хүргэдэг. Хуваагдсан хурдны интернэт нь өрхийн хэрэгцээнд зориулагдсан бөгөөд дундын сүлжээ ашигладаг тул ачааллаас хамаарч хурд нь буурдаг. Харин бодит хурдны интернэт нь албан байгууллагад зориулагдсан, тухайн хэрэглэгчидтэй шууд холбогдсон шилэн кабель ашигладаг тул 24/7 цагийн турш хурдаа бусадтай хуваалцахгүй, гэрээт хурдаа тогтмол барьдгаараа онцлогтой.

7070-XXXX БРЭНД ДУГААР

Үнэ цэнэ оршино” бэлгэдэлтэй 7070-xxxx брэнд дугаарыг бизнесийн байгууллагад зориулан худалдаанд гаргаж байна. Уг брэнд дугаарыг эзэмших нь бизнесийн байгууллага нь улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж, салбараа манлайлан, тогтвортой үйл ажиллагаа явуулж, амжилттай ажиллаж байгаа аж ахуйн нэгж байх бөгөөд энэхүү 7070-xxxx брэнд дугаар нь Таны бизнесийн нэр хүндийг илэрхийлэх болно.



NATIONAL КАБЕЛИЙН ТЕЛЕВИЗ

Монголын Цахилгаан Холбоо ХК нь анх 1997 оноос Кабелийн телевизийн үйлчилгээг нэвтрүүлэн Улаанбаатар хот, Багануур дүүрэг болон Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Ховд, Хэнтий зэрэг 14 аймагт үйлчилгээг хүргэж байна. National CaTV-н үйлчилгээг хэрэглэгчдэдээ дуу, дүрсний өндөр чанартай хүргэхийн тулд дотоодын телевизүүдийн студитэй шилэн кабелиар холбогдож, телевизийн эфирийн сигналыг өндөр нягтаршилтай хүлээн авч дахин дамжуулдаг



TV ROOM

TV room нь IPTV технологийн хөгжлийн дараагийн үе OTT технологи дээр суурилсан интернэтээр дамжуулан телевизийн суваг болон видео контентын дуу, дүрсний өндөр чанартайгаар бүх төрлийн ухаалаг төхөөрөмжөөр үзэх боломжтой үйлчилгээ юм.



ОЛОН УЛСЫН ЯРИАНЫ 001 ГАРЦ

Олон Улсын ярианы 001 гарцаар дурын суурин утас болон гар утас ашиглан дэлхийн 56 гаруй улсын хэрэглэгчидтэй холбогдох боломжтой.



ИТГЭЛТЭЙ УТАС

Статистик мэдээллээс үзэхэд, ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчдын 87% буюу 331,633 хүүхэд өдөр тутамдаа гар утас ашигладаггүй байна. Түүнчлэн, гар утастай байсан ч цэнэг дуусах, нэгжгүй болох, сүлжээ тасрах зэрэг гэнэтийн бэрхшээлүүд хүүхдүүдэд байнга тулгардаг. Энэхүү бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлан бид хуучин цагийн таксофон үйлчилгээг 2023 онд бүрэн шинэчилж, "Итгэлтэй утас" төслийг үндэсний хэмжээнд амжилттай нэвтрүүлээ. Энэ нь хүүхэд багачуудад ямар ч саадгүйгээр, хэзээ ч хамаагүй ар гэрийнхэнтэйгээ үнэ төлбөргүй холбогдох хамгийн найдвартай боломжийг бүрдүүлж буй чухал үйлчилгээ юм.



CALL CENTER - ДУУДЛАГЫН ТӨВ

Call center нь тухайн байгууллагын харилцагчийн үйлчилгээний үүргийг гүйцэтгэх технологийн шийдэл бөгөөд бизнестээ Call center үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчийн үйлчилгээтэй холбоотой зардлыг бууруулан, ажлын бүтээмж, борлуулалтыг нэмэгдүүлж, харилцагчийн сэтгэл ханамжийг сайжруулах чухал ач холбогдолтой юм. Монголын цахилгаан холбоо ХК-иас суурин утасны хэрэглэгчдэдээ зориулан одоо ашиглаж буй олон нийтэд танигдсан суурин утасны дугаар, телефон аппаратаа өөрчлөхгүйгээр Call center үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлж, зах зээлийн жишгээс хямд үнэ тарифаар хэрэглэгч танд санал болгож байна.



MIP 70


MIP70 нь хил хязгааргүй, орон зайнаас үл хамааран дэлхийн хаанаас ч интернэт орчинд телефон яриа хийх, SIP технологид суурилсан урьдчилсан төлбөрт үйлчилгээ юм.



ХЭРЭГЛЭГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

УРАМШУУЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Гүйцэтгэх захирлын 2025 оны 6 сарын 5-ны өдрийн А/101 хөнгөлөлт урамшуулал үзүүлэх тушаалаар 6 сарын 5-наас 8 сарын 6-ны хооронд компанийн хэмжээнд шинээр 780 хэрэглэгч анхны холболтын суурь хураамжаас 100% чөлөөлж, тус хөтөлбөрийн хүрээнд КАТВ-ийн 12.0 сая төгрөг бусад үйлчилгээний орлого сар бүр 19.8 сая төгрөг жилдээ 238.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж бүрдсэн.



2. FTTH төслийн хүрээнд 4100 хэрэглэгчээр нэмсэн.

- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум
- Булган аймгийн Сэлэнгэ сум
- Архангай аймгийн Цэнхэр сум
- Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум
- Баянхонгор аймаг Галуут, Хүрээмарал сум
- Хэнтий аймаг Жаргалтхаан сум
- Дорноговь аймаг Даланжаргалан сум
- Дундговь аймаг Гурвансайхан сум
- Дорнод аймаг Цагаан Овоо, Матад, Булган сумд
- Өвөр хангай аймаг Баян-Өндөр сум



3. Аймаг, дүүрэг, бүсийн холбооны газрууд 2025 онд 33 One page урамшууллын хөтөлбөр баталж 1163 хэрэглэгч төлөвлөснөөс 964 хэрэглэгч шинээр холбож ажилласан. Энэхүү хөтөлбөр хэрэгжүүлснээр сард 45.9 сая төгрөг, жилд 549.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж бүрдсэн.



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН / АУДИТЛАГДСАН /

Санхүү тайлан /сая.төг/	2024	2025
Эргэлтийн хөрөнгө	15,932.8	9,856.7
Үндсэн хөрөнгө	48,495.1	49,042.3
Нийт хөрөнгө	64,427.9	58,899.1
Нийт ор толбор	15,489.6	10,432.5
Эздийн өмч	48,938.3	48,466.6
Өр толбор ба эздийн өмч	64,427.9	58,899.1

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН / АУДИТЛАГДСАН /

Орлого үр дүн /сая.төг/	2024	2025
Нийт Орлого	26,926.3	19,865.7
Нийт Зардал	26,815.0	19,827.3
Татварын өмнөх ашиг	111.3	38.3
Орлогын татвар	52.6	30.1
АШИГ	58.7	8.2

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2026.04.07-ны өдрийн хаалтын ханшаар 16,556,976,640 төгрөг байна. Сүүлийн 52 долоо хоногийн ханшийн мэдээлэл графикаар үзүүлэв.

52 ДОЛОО ХОНОГ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ / 2026.04.07 /





ДЭЭД ХАНШ: 848
ДООД ХАНШ: 475
ХААЛТЫН ХАНШ: 640

2021-2026 ОНЫ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны мэдээлэл	2021	2022	2023	2024	2025	2026.04.07
Хувьцааны тоо /сая/25.9	25.9	25.9	25.9	25.9	25.9	25.9
Нэгж хувьцааны 33-ийн үнэ /ХХ/712	712	502	550	540	718	640
Зах зээлийн үнэлгээ /сая/18,420.9	18,420.9	12,986.9	14,228.7	13,969.9	18,574.9	16,557.0
ROA	0.01%	0.02%	0.04%	0.09%	0.1%	0.26%
ROE	0.01%	0.03%	0.06%	0.12%	0.2%	0.30%
EPS	0.2	0.4	1.1	2.3	0.3	5.6
P/E	3,906.7	1,417	493.1	238.1	2,266.2	114.6
Нэгж хувьцааны бодит үнэ цэн/1,333	1,333	48,466.6	1,947	1,892	1,873	1,879
P/B харьцаа0.53	0.53	0.35	0.28	0.29	0.38	0.34

2021-2026 ОНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2021-2026 ОНЫ ХААЛТЫН ХАНШ

2025 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2024-2025 ОНД ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ

Үзүүлэлт / мян.төг /	2024	2025
Төсвийн төлбөрт нийт дүн	3,237,897.9	4,314,975.8
а/ Орлогын татварт	-	50,158.2
б/ НӨТ	749,000.5	1,588,295.7
в/ НДШ	1,880,547.1	2,076,617.1
г/ Хүн амын орлогын татвар	569,347.9	549,021.3
д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	21,113.9	33,423.8
э/ Тээврийн хэрэгслийн татвар	2,591.3	15,787.5
ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	15,297.2	1,672.3

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн, нийт 9 гишүүнтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Ц.Баяр-Эрдэнэ, ердийн гишүүнээр Д.Нарангэрэл, Б.Төрбат, А.Молор, Б.Билэгдэмбэрэл, С.Ганзориг, хараат бус гишүүнээр Х.Баянбай, Н.Туул, С.Цолмон нар ажиллалаа. ТУЗ-ийн бүрэлдэхүүн ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө 2025 оны 5 сарын 01-ээс дараа оны буюу 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хэрэгжихээр шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөнд ээлжит 11 хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалт, бусад үйл ажиллагаа буюу ТУЗ, дэргэдэх хороод өөрийн үнэлгээ хийх, дүгнэх, компанийн мөрдөж байгаа цалин урамшууллын бодлого, эрх зүйн акт нь бизнес төлөвлөгөө, ажилтны ажлын үр дүнтэй уялдаж байгаа талаарх үнэлэлт дүгнэлт хийх, компанийн салбар нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах чиглэлээр ажиллах зэрэг онцлог бүхий 13 үйл ажиллагааг хийж гүйцэтгэхээр тусгаж, үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувьтай биелсэн байна.

ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл 10 удаа, хороод 8 удаа, ажлын хэсэг 2 удаа тус тус хуралдсан. ТУЗ-ийн хурлыг танхимаар зохион байгуулахыг зорьж ажилласан бөгөөд 8 удаагийн хурлыг танхимаар, 2 удаа цахимаар хуралдаж нийт 27 асуудал хэлэлцэн шийдвэрлэж 13 тогтоол, 4 тэмдэглэл гарган хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин ажиллалаа. Хурлаар хэлэлцэх асуудал хугацаандаа тайлагнах боломжгүй байдлаас шалтгаалан нэг удаагийн хурлыг хойшлуулсан байна.

ХУРЛЫН ИРЦ

2025 онд ТУЗ-ийн хурлын ирц хурлын ирц 99 хувь байлаа. Хурлыг тасалсан болон чөлөө авсан гишүүн байгаагүй.

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Хурлын дугаар										Гишүүний ирц	
	213	214	215	216	217	218	219	220	221	222		
Х.Баянбай	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Б.Төрбат	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
С.Цолмон	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Ц.Баяр-Эрдэнэ	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
А.Молор	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Д.Нарангэрэл	и	и	и	и	и	и	е	и	и	и	и	100%
Б.Билэгдэмбэрэл	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
С.Ганзориг	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Н.Туул	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Хурлын ирц:	100%	100%	100%	100%	100%	100%	89%	100%	100%	100%		
Хурлын хэлбэр	танхим	танхим	танхим	танхим	танхим	танхим	танхим	цахим	танхим	цахим		

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гэсэн гурван хороодтой байдаг.

АУДИТЫН ХОРОО

Даргаар хараат бус гишүүн Х.Баянбай, гишүүдээр хараат бус гишүүн С.Цолмон, ердийн гишүүн С.Ганзориг нар ажиллаа.

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сургалт, орон нутгийн салбаруудын үйл ажиллагаатай танилцах дотоод томилолтын зардлын тооцооллыг боловсруулан, биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

2.“МЦХ” ХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ТУЗ-д ирүүлсэн албан бичигтэй танилцсан. Үр дүн, Аудитын хороо санал, дүгнэлт гаргах шаардлагагүй, 2026 оны компанийн жилийн бизнес төлөвлөгөө батлах тухай асуудал хэлэлцэхэд харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэв.

3.Компанийн 2026 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний талаар санал, дүгнэлтээ гарган ТУЗ-ийн хуралд танилцуулсан.

4. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгч, санал дүгнэлтээ ТУЗ-ийн хурлаар танилцуулж, хэлэлцүүлсэн

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Даргаар хараат бус гишүүн С.Цолмон, гишүүдээр ердийн гишүүн А.Молор, хараат бус гишүүн Н.Туул нар ажиллаа. Тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хороо дараах үйл ажиллагааг явууллаа.

1.Гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг дүгнэх асуудлаар ажилчдаас авах санал асуулгыг боловсруулан судалгаа авч, гэрээний хавсралтын дагуу үнэлж, санал дүгнэлтээ ТУЗ-ийн 2025 оны 6 сарын 31-ний өдрийн 214 дүгээр хурлаар танилцуулсан.

2.ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийн үнэлгээний тайланг ТУЗ-д танилцууллаа.

3.Төлөөлөн удирдах зөвлөл Гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нөхцөл, 2025 оны Гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн тухай Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны хамтарсан уулзалт зохион байгуулав.

4.Төлөөлөн удирдах зөвлөл Гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нөхцөл, 2025 оны Гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн тухай санал дүгнэлтээ 2025 оны 10 сарын 31-ний өдрийн ТУЗ-ийн 216 дугаар хурлаар танилцуулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны гэрээг шинэчлэн батлуулсан байна.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

Даргаар хараат бус гишүүн Н.Туул, гишүүдээр хараат бус гишүүн Х.Баянбай, ердийн гишүүн Б.Төрбат нар тус тус ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо дараах үйл ажиллагааг явууллаа.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны 2025 оны 7 сарын 04-ний өдрийн хурлаар нь Гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд тусгах саналаа боловсруулан гаргасан.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороотой хамтарсан хурлын 10 сарын 23-ны өдөр зохион байгуулж саналаа ТУЗ-ийн хурлаар танилцуулж, хэлэлцүүлээ.

3. ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан “Компанийн цалин урамшууллын бодлого, эрх зүйн акт нь бизнес төлөвлөгөө, ажилтны ажлын үр дүнтэй уялдаж байгаа талаарх үнэлэлт дүгнэлт хийх” асуудлаар компанид мөрдөгдөж буй цалин хөлсний талаарх эрх зүйн баримт бичгийн тухай болон “МЦХ” ХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ТУЗ-д ирүүлсэн албан бичгийн талаар хэлэлцэн санал дүгнэлтээ ТУЗ-ийн хуралд танилцуулан хэлэлцүүлээ.

4. ТУЗ-ийн гишүүдийн цалинг олгохтой холбоотой журмын төслийг боловсруулан, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа оны буюу 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд 194,485,760 төгрөгөөр баталсан бөгөөд 177,634,840 төгрөг буюу 91.33 хувийн гүйцэтгэлтэй байна.

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн	Гүйцэтгэл
1. Цалингийн зардал						
1	ТУЗ-ийн дарга	1	1,400,000	12	16,800,000	16,800,000
2	ТУЗ-ийн хараат бус гишүүн	3	1,320,000	12	47,520,000	47,520,000
3	ТУЗ-ийн ердийн гишүүний цалин	5	1,200,000	12	72,000,000	72,000,000
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	1,200,000	12	14,400,000	14,400,000
	Цалингийн зардлын дүн				150,720,000	150,720,000
5	Нийгмийн даатгалын шимтгэл				20,045,760	14,378,400
	Дэд дүн				170,765,760	165,098,400
2. Бичиг хэрэг, хурал, холбоо, тээврийн зардал						
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	180,000	12	2,160,000	2,099,380
2	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000	-
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	180,000	12	2,160,000	1,968,700
4	Бусад зардал	1	100,000	5	500,000	-
	Дэд дүн				5,220,000	4,068,080
3. Сургалт, компанийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах зардал						
1	Сургалт, семинарын зардал				8,500,000	-
2	Томилолтын зардал				10,000,000	8,468,360
	Дэд дүн				18,500,000	8,468,360
	НИЙТ ДҮН				194,485,760	177,634,840

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн өөрийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо үнэлсэн бөгөөд ТУЗ-ийн үнэлгээ 70 хувиар үнэлэгдсэн. ТУЗ нь үйл ажиллагааны зохион байгуулалт, ил тод байдал зэрэг зарим чиглэлээр сайн үнэлгээ авч, стратеги, эрсдэл, нийгмийн хариуцлагын чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэгдсэн.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо өөрийн үнэлгээг 83.3 хувиар үнэлэж цаашид гүйцэтгэлийн үнэлгээ, ил тод байдал, тайлагнал, эрсдэл ба хариуцлагын чиглэлээр цалин, урамшууллын бодлого, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх замаар үйл ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулах боломжтой гэж дүгнэсэн байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо өөрийн үнэлгээг 81.3 хувиар үнэлэж цаашид хорооны ёс зүй, хариуцлагын чиглэлээр холбогдох журам, баримт бичгийг боловсруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо өөрийн үнэлгээг 93.3 хувиар үнэлэж хорооны бүрэлдэхүүн, хараат бус байдал, гүйцэтгэлийн үнэлгээ болон олон улсын туршлагатай нийцүүлэлтийн чиглэлүүдэд 100 хувийн үнэлгээ авсан нь үйл ажиллагааны чанар, үр нөлөө өндөр байгааг харуулж байна. Нэр дэвшүүлэх үйл явц болон ёс зүй, хариуцлагын чиглэлүүдийг сайжруулснаар ойрын хугацаанд үнэлгээг 95 хувиас дээш түвшинд хүргэх боломжтой гэж дүгнэсэн байна.

7070
ҮНЭ ЦЭНЭ
ОРШИНО

2024 ОНЫ ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ТАРААСАН ТАЙЛАН

“Монголын цахилгаан холбоо” Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 210 дугаар хурлын №02 тоот тогтоолын дагуу компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж нэгж хувьцаанд 1(нэг) төгрөг байхаар тогтоосон.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосон бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрөөр тасалбар болгосон нэрсийн жагсаалтад 4037 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байв.

Нийт 25,870,276 ширхэг хувьцаа бүртгэгдсэн бөгөөд 1,370,989 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 4,037 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг 1,274,627.15. төгрөгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан хуваарилсан.

Үүнд:

Дотоодын иргэний 3,976 хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг 1,126,294.35 төгрөгийг, гадаад улсад оршин суугч 61 хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг 148,332.8 төгрөгийг тус тус “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд шилжүүлсэн.

Мөн төрийн эзэмшлийн 24,499,287 ширхэг хувьцаанд ноогдох ногдол ашгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолыг үндэслэн Төрийн сангийн дансанд шилжүүлсэн.

№	Хувьцаа эзэмшигчийн төрөл	Хувьцааны тоо /ширхэг/	Ногдол ашгийн дүн /₮/	Татварын дараах шилжүүлсэн дүн /₮/	Тараасан хэлбэр
1	Төрийн өмч	24,499,287	24,499,287	24,499,287	Төрийн сан дахь ТӨБЗГ-ын данс
2	Монгол улсын иргэн, хуулийн этгээд нийт 4037 хувьцаа эзэмшигч	1,185,573	1,185,573	1,067,015.7	ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хуваарилсан
3	Гадаадад амьдардаг иргэн, хуулийн этгээд нийт 61 хувьцаа эзэмшигч	185,416	185,416	148,332.8	ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хуваарилсан
4	Татвар суутгасан дүн	-	-	155,640.5	
	Нийт дүн	25,870,276	25,870,276	25,870,276	

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/714
танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЧИНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 327.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 68.8 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал;

- Арваас дээш жилийн насжилттай 129.1 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй;
- Жижиг мөнгөн сангийн гүйлгээний хязгаарыг 96.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- ТУЗ-ийн гишүүдэд 45.4 сая төгрөгийн цалин, хөлс илүү олгосон;
- Зориулалт тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэлгүй 37.2 сая төгрөг зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, 13.4, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3, Нийгмийн даатгалын сангаас олгох

Z:\Yawsan_Bichig\2026\0316 SAG-59.Docx

1526141207

тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын Их Хурлаар 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төсөлд Монголын цахилгаан холбоо ХК-ийн энгийн хувьцааг нэмж гарган, биржээр олон нийтэд нээлттэй худалдахаар тусгажээ. Монголын хөрөнгийн биржээр 2025 онд 109 өдөр 14,215 ширхэг нийт 9.7 сая төгрөгийн хувьцааны арилжаа явагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн гол чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг 2024 онд сонгон шалгаруулж, 2025 онд Ординат ХХК-ийн нийлүүлсэн Юникус програмыг ашиглан санхүүгийн тайланг бэлтгэсэн бөгөөд шинэ системд шилжсэнтэй холбоотойгоор зарим дансны ангилал, кодчлолын алдаа гарч, дансны тохиргоо бүрэн оновчтой хийгдээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь АДБОУ-ын стандартын дагуу аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	484,906,162.75	155,508,788.12
1.1.2	Дансны авлага	6,847,874,274.85	3,625,488,303.47
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	11,690,176.25	25,717,964.99
1.1.4	Бусад авлага	1,587,390,879.12	2,114,936,511.09
1.1.6	Бараа материал	3,212,389,509.63	2,651,363,151.03
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,788,503,981.63	1,283,718,556.27
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	15,932,754,984.23	9,856,733,274.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	38,303,984,017.64	38,753,685,386.84
1.2.2	Биет бус хөрөнгө	10,024,622,061.59	10,146,117,842.55
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	166,530,700.63	142,519,443.63
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48,495,136,779.86	49,042,322,673.02
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	64,427,891,764.09	58,899,055,948.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,288,431,914.57	3,200,885,186.03
2.1.1.3	Татварын өр	1,860,381,683.90	1,436,707,634.40
2.1.1.4	НДШ-ийн өглөг	184,432.26	6,113,429.01
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг	154,365,413.66	153,091,625.61
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	366,847,275.06	287,841,031.14
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	4,050,346,519.30	2,716,825,269.46
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,720,557,238.75	7,801,464,175.65
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,503,973,693.32	1,503,973,693.32
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,265,024,580.52	1,127,055,955.09
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,768,998,273.84	2,631,029,648.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	15,489,555,512.59	10,432,493,824.06
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	2,449,928,700.00	2,449,928,700.00
2.3.2	-хувийн	137,098,889.00	137,098,889.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,088,188,462.23	14,088,188,462.23
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
2.3.9	Хуримтлагдсан ашиг	24,015,850,027.88	23,544,075,900.32
2.3.11	Эздийн өмчийн дүн	48,938,336,251.50	48,466,562,123.94
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	64,427,891,764.09	58,899,055,948.00

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	25,097,594,083.63	18,825,283,426.45
2	Борлуулалтын өртөг	19,628,981,359.43	12,617,243,803.76
3	Нийт ашиг(алдагдал)	5,468,612,724.20	6,208,039,622.69
4	Түрээсийн орлого	534,370,170.83	768,627,150.08
5	Хүүний орлого	68,102,080.28	1,818,284.98
8	Бусад орлого	164,732,631.72	266,977,908.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,123,680,670.16	2,236,073,324.39
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,057,167,663.25	4,271,056,766.46
11	Санхүүгийн зардал	1,185,265,879.95	650,484,122.57
12	Бусад зардал	833,192,215.99	47,160,162.39
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(371,088.35)	(2,346,998.77)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	71,842,077.80	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	107,982,167.13	38,341,591.44
19	Орлогын татварын зардал	49,306,373.81	30,145,088.26
20	Татварын дараах ашиг (алдагдал)	58,675,793.32	8,196,503.18
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	58,675,793.32	8,196,503.18
24	Орлогын нийт дүн	58,675,793.32	8,196,503.18
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдалтай)	58,675,793.32	8,196,503.18

САГ-2026/54/НА-СТА-ТӨҮГ



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	25,445,254,001.61	50,367,740,225.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,488,079,767.05)	1,488,079,767.05
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				58,675,793.32	58,675,793.32
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	24,015,850,027.88	48,938,336,251.50
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(479,970,630.74)	(479,970,630.74)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				8,196,503.18	8,196,503.18
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	23,544,075,900.32	48,466,562,123.94

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,578,409,128.05	20,177,363,839.95
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,064,339,500.91	18,348,271,383.70
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	872,778.00	-
	Бусад мөнгөн орлого	6,513,196,849.14	1,829,092,456.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,546,346,736.77	18,694,989,455.32
	Ажиллагчдад төлсөн	6,647,911,351.92	7,407,686,789.51
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,880,547,081.74	2,076,617,056.58
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,929,480,951.29	3,732,507,199.04
	Ашиглалтын зардалд төлсөн	3,048,465,985.56	2,181,691,020.42
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	435,529,071.33	369,244,706.54
	Хүүгийн төлбөрт төлсөн	1,018,172,729.27	-
	Татварын байгууллагад төлсөн	1,357,350,804.84	2,314,301,012.94
	Даатгалын төлбөрт төлсөн	38,473,348.00	-
	Бусад мөнгөн зарлага	2,190,415,412.82	612,941,670.29
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,032,062,391.28	1,482,374,384.63
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,171,182.68	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаан буцаан төлөлт	12,599,002.00	-
	Хүлээн авсан хүүний орлого	572,180.68	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,245,886,254.00	1,053,058,592.35
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,166,508,854.00	913,358,592.35
	Биет бус хөрөнгө хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	79,377,400.00	139,700,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,232,715,071.32)	(1,053,058,592.35)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,211,257.88	80,599,970.06
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	80,599,970.06
	Бусад орлого	1,211,257.88	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	67,738,673.10	839,313,136.97
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	31,583,897.25	675,571,436.49
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	30,975,419.48	137,968,625.43
	Төлсөн ногдол ашиг	5,066,470.00	25,773,075.05

САГ-2026/54/НА-СТА-ТӨҮГ



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

	Бусад зарлага	112,886.37	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(66,527,415.22)	(758,713,166.91)
4	Валютын ханшийн зөрүү	303,338.26	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(266,876,757.00)	(329,397,374.63)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	751,782,919.75	484,906,162.75
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	484,906,162.75	155,508,788.12


Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэтгэл	Хувь
	Б		1	2	3	4=3-1	5	6=3-2	7
1.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:	м.төг	26,632,129.3	26,002,932.7	19,862,706.8	(6,769,422.5)	74.6	(6,140,225.9)	76.4
	Суурин утасны үйлчилгээ	м.төг	7,577,600.0	9,060,224.0	7,944,674.4	367,074.4	104.8	(1,115,549.6)	87.7
	Интернэтийн үйлчилгээ	м.төг	4386,797.4	7,561,072.7	4,445,136.1	58,338.7	101.3	(3,115,936.6)	58.8
	FTTH үйлчилгээ	м.төг	1,752,547.0	4,720,532.2	2,569,142.7	816,595.7	146.6	(2,151,389.5)	54.4
	Колл центр	м.төг	311,804.2	295,490.0	338,776.1	26,971.8	108.6	43,286.1	114.6
	КаТв, ОТТ, Лавлах үйлчилгээ	м.төг	1,778,999.8	1,610,427.6	1,896,890.2	117,890.4	106.6	286,462.6	117.8
	Бусад орлого	м.төг	9,824,215.8	2,265,308.8	1,766,888.1	(8,057,327.7)	18.0	498,420.6	78.0
	МТС Сервис орлого	м.төг	1,000,165.1	489,877.4	901,199.2	(98,965.9)	90.1	411,321.8	183.9
2.	Нийт орлого	м.төг	26,926,267.7	26,070,870.6	19,862,706.8	(7,063,560.9)	73.8	(6,208,163.8)	76.2
3.	Нийт зардал	м.төг	26,814,983.7	25,912,779.7	19,824,365.2	(6,990,618.5)	73.9	(6,088,414.5)	76.5
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	3,057,167.7	3,452,741.9	4,271,056.8	1,213,889.0	139.7	818,314.9	123.7
4.	Татварын өмнөх ашиг	м.төг	111,284.0	158,090.8	38,341.6	(72,942.4)	34.5	(119,749.2)	24.3
5.	Цэвэр ашиг /алдагдал	м.төг	58,675.8	142,281.8	8,196.5	(50,479.3)	14.0	(134,085.3)	5.8
6.	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	3,237,897.9	4,147,100.0	4,314,975.8	1,077,077.9	133.3	167,875.8	104.0
	а/Орлогын татварт	м.төг	-	100,000.0	50,158.2	50,158.2	-	(49,841.8)	50.2
	б/НӨАТ	м.төг	749,000.5	1,600,000.0	1,588,295.7	839,295.2	212.0	(11,704.3)	99.3
	в/НДШ	м.төг	1,880,547.1	1,850,000.0	2,076,617.0	196,069.9	110.4	226,617.0	112.2
	г/Хүн амын орлогын татвар	м.төг	569,347.9	550,000.0	549,021.3	(20,326.6)	96.4	(978.7)	99.8

СНАГ-2025/033/НА-СТА-ТӨҮГ


 Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	21,113.9	24,000.0	33,423.8	12,309.9	158.3	9,423.8	139.3
	з/Гээврийн хэрэгслийн татвар	м.төг	2,591.3	8,100.0	15,787.5	13,196.2	609.2	7,687.5	194.9
	ж/Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	15,297.2	15,000.0	1,672.3	(13,624.9)	10.9	(13,327.7)	11.1
7.	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	5,066.5	-	25,773.1	20,706.6	508.7	25,773.1	-
8.	Нийт ажиллагсдын тоо	хүн	513	690	493	(20)	96.1	(197)	71.4
9.	Нийт цалингийн сан	м.төг	7,035,445.5	8,760,468.0	8,050,331.6	1,014,886.1	114.4	(710,136.4)	91.9
10.	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,089.8	1,058.0	1,360.8	271.0	124.9	302.8	128.6
11.	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1	0.99	1.0	0	100.2	0	101.0
12.	Хөрөнгө оруулалт	м.төг	3,586,818.1	3,960,890.0	1,438,894.9	(2,147,923.2)	40.1	(2,521,995.1)	36.3
13.	Нийт авлага	м.төг	8,446,955.3	4,084,807.6	5,766,142.8	(2,680,812.5)	68.3	1,681,335.2	141.2
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
	Нийт өглөг	м.төг	15,489,555.5	8,335,278.3	10,432,493.8	(5,057,061.7)	67.4	2,097,215.5	125.2
14.	Богино хугацаат өр төлбөр	м.төг	12,720,557.2	5,754,965.6	7,801,464.2	(4,919,093.0)	61.3	2,046,498.6	135.6
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	2,768,998.3	2,580,312.7	2,631,029.6	(137,968.7)	95.0	50,716.9	102.0

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРОО ДҮГНЭЛТ

2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын үр дүнгийн талаар
/САГ-2026/54/НА-СИА-ТӨҮГ/

I. ХӨНДЛӨНГИЙН АУДИТОРЫН ДҮГНЭЛТИЙН ТАЙЛБАР

1.1. Дүгнэлтийн төрөл: Хязгаарлалттай дүгнэлт

МЦХ ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээгээр “Ниямазон-Аудит” компани аудит хийж, “хязгаарлалттай дүгнэлт” өгсөн байна.

Хязгаарлалттай дүгнэлт гэдэг нь санхүүгийн тайлан бүхэлдээ буруу биш боловч илэрсэн алдаа, зөрчлийн дүн материаллаг түвшнээс давсан гэсэн утгатай бөгөөд МХБ-д бүртгэлтэй компанийн хувьд хөрөнгө оруулагчдын итгэлд нөлөөлж болзошгүй байна.

Тус компанийн 2025 оны материаллаг түвшнийг 2024 оны нийт зардлын 1.0 хувиар буюу 258.3 сая төгрөгөөр тогтоосон байна.

1.2. Залруулагдаагүй зөрчил /327.1 сая төгрөг/

№	ЗӨРЧЛИЙН АГУУЛГА	ДҮН	ТАЙЛБАР
1	Арваас дээш жилийн насжилттай авлагатай. Авлага барагдуулах арга хэмжээ аваагүй	129.1	Зөвлөмж
2	Жижиг мөнгөн сангийн хязгаарыг хэтрүүлэн зарцуулсан	96.3	Албан шаардлага
3	ТУЗ нь тайлант хугацаанд 8 удаа хуралдсан боловч 12 хурлаар тооцсон цалин олгосон	45.4	Албан шаардлага
4	Харилцах данс болон жижиг мөнгөн сангаас зориулалт нь тодорхойгүй мөнгө зарцуулсан	30.4	Албан шаардлага
5	Жижиг мөнгөн сангаас баримтгүй мөнгө зарцуулсан	6.8	Төлбөрийн акт
6	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг давхардуулан олгосон	2.9	Төлбөрийн акт
7	И-баримтгүй худалдаж авсан бараа материал	16.2	Зөвлөмж
	ЗАЛРУУЛАГДААГҮЙ ЗӨРЧЛИЙН ДҮН	327.1	

1.3 Нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

№	ЗӨРЧИЙН АГУУЛГА	ТАЙЛБАР
1	ТУЗ-ийн хурлаар баталсан 2025 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түшингийн орлогын төлөвлөгөөг тасалсан	Албан шаардлага
2	Сонгон шалгаруулалтгүйгээр нийлүүлэгчдээс төхөөрөмж худалдаж авсан. Хэрэглэгчдэд түгээсэн, төлбөр орж ирснийг баталгаажуулахгүйгээр Дэлгэрэхбилэг ХХК-д 49.5 сая, Гүн цэнхэр огторгуйХХК-д 82.5 сая төгрөг, Наран ХХК-д 150.0 сая төгрөг шилжүүлсэн	Зөвлөмж
3	Тендерийн баталгааг архивлаагүй, тендерт материал ирүүлсэн болон нээсэн хугацааг тэмдэглээгүй, тендер нээх хугацааг мөрдөөгүй	Зөвлөмж

1.4 Аудитын явцад залруулсан алдаа, зөрчил /2,871.9 сая төгрөг/

Дараах алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан байна:

АЛДАА, ЗӨРЧИЙН АГУУЛГА	ДҮН
Түрээсийн авлагыг татвар, НДШ-ийн авлагаар тайлагнасан	487.1
Түрээсийн орлого болон хүүгийн орлогыг ангилал зөрүүлэн тайлагнасан	770.5
Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-д төлөх сүлжээ ашигласны төлбөрийг дутуу тайлагнасан	233.0
Голомт банкин дахь харилцахын үлдэгдлийг илүү илэрхийлсэн	10.0
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг дутуу илэрхийлсэн	1,371.3
ЗАЛРУУЛСАН АЛДАА, ЗӨРЧИЙН ДҮН	2,871.9

II. САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮГНЭЛТ

2.1 Санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТ	2024 ОН (САЯ ТӨГРӨГ)	2025 ОН (САЯ ТӨГРӨГ)	ХАНДЛАГА
Нийт хөрөнгө	64,427.9	58,899.1	-5,528.8
Нийт орлого	26,926.3	19,862.7	-7,063.6
Татварын өмнөх ашиг	111.3	38.4	-72.9
Цэвэр ашиг	58.7	8.1	-50.6
Нийт авлага	8,446.9	5,766.1	-2,680.8
Нийт өглөг	15,489.6	10,432.5	-5,057.1

III. ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ДҮГНЭЛТ

3.1 Дотоод хяналтын гол сул талууд

- Жижиг мөнгөн сангийн хязгаар тогтоосон боловч мөрдүүлэх механизм хангалтгүй, 96.3 сая төгрөгөөр хэтэрсэн
- ТУЗ-ийн гишүүдийн цалинг тооцож олгох журамгүй.
- Нягтлан бодох бүртгэлийн программ 2024 онд сонгон шалгаруулж, 2025 онд шилжсэн, шилжилтийн үед ангиллын алдаа, кодчиллын дутагдал гарсан
- Авлага барагдуулах арга хэмжээ системтэй хэрэгжүүлэгдэхгүй. Хугацаа хэтэрсэн 129.1 сая төгрөгийн найдваргүй авлагатай
- Баримтын бүрдэлтийн хяналт сул, 56.3 сая төгрөгийн зориулалт тодорхой бус зардал гаргасан

3.2 Эерэг тал

- 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1 төлбөрийн акт, 4 албан шаардлага, 1 зөвлөмжийн өгснийг бүрэн биелүүлсэн.
- Өмнөх онтой харьцуулахад авлагын оны эцсийн үлдэгдэл 31.7 хувь, өглөгийн үлдэгдэл 32.6 хувиар буурсан.
- Ажиллагсдын дундаж цалин 271.0 мянган төгрөгөөр өссөн.

IV. МХБ-ИЙН БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

4.1 Ил тод байдал, мэдээлэл задруулалд

- МХБ-д бүртгэлтэй компанийн хувьд санхүүгийн тайлагналын чанар, цаг тухайд нь мэдээлэл задруулах үүрэг онцгой чухал:
- Санхүүгийн тайлангийн аудит хийгдсэн, дүгнэлт нь хязгаарлалттай тул МХБ-ийн жагсаалтын шаардлагыг хангахад эрсдэл үүсэж болзошгүй
- 2025–2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төслийн хүрээнд хувьцааны ил тод байдалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай
- Монголын хөрөнгийн бирж дээр 2025 онд 109 өдөр 14,215 ширхэг нийт 9.7 сая төгрөгийн хувьцааны арилжаа явагдсан

4.2 Аудитын хорооны санал

- Санхүүгийн тайлангийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор дараагийн тайлант жилд зөрчилгүй дүгнэлт авахыг зорих
- Хувьцаа эзэмшигчдэд тайлагнах арга механизмыг бэхжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг чанартай, цаг тухайд нь гаргах
- Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах системтэй арга хэмжээ авах



Call Center
дуудлага бүрийг холбоно

V. АУДИТЫН ХОРООНЫ ШААРДЛАГА БА ЗӨВЛӨМЖ

5.1 Удирдлагад тавих шаардлага

№	ШААРДЛАГЫН АГУУЛГА	БИЕЛЭЛТИЙН ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД
1	Хуучин насжилттай 129.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээний төлөвлөгөө гаргах	2026.06.01	Санхүүгийн захирал
2	Жижиг мөнгөн сангийн дотоод журам шинэчлэн, хяналтын механизм тогтоох	2026.06.01	Дотоод аудит
3	ТУЗ-ийн гишүүдийн цалинг тооцож олгох журамтай болох	2026.07.01	ТУЗ/Цалин урамшууллын хороо
4	Хуучин насжилттай 129.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээний төлөвлөгөө гаргах	2026.06.01	Нягтлан бодогч
5	Жижиг мөнгөн сангийн дотоод журам шинэчлэн, хяналтын механизм тогтоох	2026.05.01	Санхүүгийн баг

VI. ДҮГНЭЛТ БА ТАЙЛБАР

6.1 Аудитын хорооны дүгнэлт

Аудитын хороо дараах дүгнэлтэд хүрсэн болно:

- МЦХ ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хязгаарлалттай дүгнэлт өгсөн нь ноцтой байдал бөгөөд хөрөнгө оруулагчдын итгэлд нөлөөлж болзошгүйг анхаарах.
- Аудитын байгууллагаас илрүүлсэн алдаа зөрчлүүд нь байгууллагын дотоод хяналт болон компанийн санхүүгийн удирдах ажилтнуудын хариуцлага сул байгааг харуулж байна. Иймд ТУЗ-ийн дэргэд дотоод аудитын нэгж ажиллуулах, ерөнхий нягтлан бодогчийг өөрчлөх арга хэмжээ авах.
- Цэвэр ашиг 2024 оноос 86%-аар буурсан нь зөвхөн зах зээлийн нөхцөл биш, зардлын удирдлагын асуудалтай холбоотой болохыг анхаарах.
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, цагийн бүртгэлийн талаар тодорхой журамтай болж, зөрчилгүй ажиллах.

6.2 Биелэлтийн хяналт

2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах тодорхой төлөвлөгөө гаргаж, Аудитын хороогоор хянуулан, ТУЗ-ийн хуралд танилцуулах, биелэлтийг удирдлагын санаачилгаар тухай бүрд ТУЗ-ийн хуралд танилцуулж байх.

АУДИТЫН ХОРОО



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
221 ДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 4 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын
дүгнэлтийн тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дүрмийн 7.19.9 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:


1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд “Хангалттай”, санхүүгийн тайланг “Сайжруулах шаардлагатай” гэж тус тус дүгнэсүгэй.

2. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар тогтсугай.

3. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос гаргасан дүгнэлтийг тус тус хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

4. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

2025 ОНЫ ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 219 ДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.7, 46.8 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дугаар заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоол, Монголын цахилгаан холбоо ХК-ийн “Ногдол ашгийн журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны цэвэр ашгийн 80 хувь буюу 12,218,940.09 (арван хоёр сая хоёр зуун арван найман мянга есөн зуун дөч зууны ес) төгрөгийг ногдол ашигт хуваарилж, нэгж хувьцаанд 0.47 (тэг зууны дөчин долоо) төгрөг байхаар тогтоон мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.

3. Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулан, 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгосугай.

4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТОГТООЛ, ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮД, НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.2, 81.5.3 дахь заалт, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дүрмийн 7.18 дахь заалт, “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Н.Туул, С.Цолмон, Х.Баянбай, Н.Данзандагва, С.Солонго нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА

С.ЦОЛМОН

ГИШҮҮД:

Н.ТУУЛ

А.МОЛОП



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.2, 81.5.3 дахь заалт, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дүрмийн 7.18 дахь заалт, “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Н.Туул, С.Цолмон, Х.Баянбай, Н.Данзандагва, С.Солонго нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА

С.ЦОЛМОН

ГИШҮҮД:

Н.ТУУЛ

А.МОЛОР

“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

2026 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийг 79.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг үндэслэн “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 220 дугаар хурлын 01 дүгээр тогтоолоор компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3 гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэг хууль, журамд заасны дагуу нэр дэвшигчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг боловсруулж, сонгон шалгаруулалтын зарыг Зууны мэдээ сонины 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн №056 (7798) дугаар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас, компанийн цахим хуудас, фэйсбүүк хуудас, МҮОНТ, toim.mn мэдээллийн сүлжээгээр 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зарласан.

Сонгон шалгаруулалтын зарын дагуу tsetsegmaa@mtcone.net цахим шуудангийн хаягаар нийт 8 нэр дэвшигч нэрээ дэвшүүлэн холбогдох материалыг дараах байдлаар бүрдүүлэн ирүүлсэн байна. Үүнд:

1. Т.Батсайхан /29 хуудас материал/
2. Б.Энхцэцэг /23 хуудас материал/
3. Н.Туул /38 хуудас материал/
4. Х.Баянбай /30 хуудас материал/
5. Н.Данзандагва /31 хуудас материал/
6. С.Цолмон /38 хуудас материал/
7. Г.Лхамдулам /26 хуудас материал/
8. С.Солонго /27 хуудас материал/

Сонгон шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл, нэр дэвшигчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлага хангасан эсэх үнэлгээг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, ярилцлагын шатны үнэлгээг 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан бөгөөд дараах үр дүнг гарлаа. Үүнд:

1. Баримт бичгийн бүрдэл, нэр дэвшигчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлага хангасан байдлыг үнэлэхэд Т.Батсайхан-59 оноо, Б.Энхцэцэг-62.3 оноо, Н.Туул-66.3 оноо, Х.Баянбай-66.3 оноо, Н.Данзандагва-65.7 оноо, С.Цолмон-65.7 оноо, Г.Лхамдулам-57.7 оноо, С.Солонго-64.2 оноогоор үнэлэгдлээ. “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын 5.3-т заасны дагуу хамгийн өндөр оноо авсан 5 оролцогч буюу Х.Баянбай, Н.Туул, С.Цолмон, Н.Данзандагва, С.Солонго нарыг ярилцлагын шатанд оролцуулахаар шийдвэрлэв.
2. Ярилцлагыг цахимаар Zoom программ ашиглан, шалгарсан оролцогч тус бүрээс 30 хүртэл оноотой 3 асуултын хүрээнд ярилцлагыг зохион байгуулсан. Нэр дэвшигчийн асуултад хариулсан байдалд ажлын хэсгийн гишүүн тус бүр

үнэлгээ өгч, нийт дүгнэсэн онооны дунджаар Н.Туул-23 оноо, Х.Баянбай-20.7 оноо, Н.Данзандагва-20.7 оноо, С.Цолмон-21.7 оноо, С.Солонго-20.3 оноогоор тус тус дүгнэгдсэн.


“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3 гишүүнд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалтад нийлбэр оноогоор Н.Туул-89.3 оноо, С.Цолмон-87.3 оноо, Х.Баянбай-87 оноо, Н.Данзандагва-86.3 оноо, С.Солонго-84.2 оноотой тус тус дүгнэгдлээ.


Хүснэгт. Сонгон шалгаруулалтын оноо

Баримт бичгийн бүрдэл	Авбал зохих оноо	1	2	3	4	5	6	7	8
		Т.Батсайхан	Б.Энхцэцэг	Н.Туул	Х.Баянбай	Н.Данзандагва	С.Цолмон	Г.Лхамдулам	С.Солонго
Баримт бичгийн бүрдэл хангасан байдал	20	16.0	14.7	17.7	18.7	18.3	16.7	16.3	18.3
Нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлага хангасан байдал	26	26.0	26.0	25.3	26.0	26.0	25.3	26.0	24.7
Нэр дэвшигчид тавигдах тусгай шаардлага хангасан байдал	24	17.0	21.7	23.3	21.7	21.3	23.7	15.3	21.2
Ярилцлагын шатны үнэлгээ	30	-	-	23.0	20.7	20.7	21.7	-	20.3
Нийт оноо	100	59.0	62.3	89.3	87.0	86.3	87.3	57.7	84.5

Иймд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаж, хамгийн өндөр оноо авсан Н.Туул, С.Цолмон, Х.Баянбай, Н.Данзандагва, С.Солонго нарыг “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх саналыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.


АЖЛЫН ХЭСГИЙН

ДАРГА  **Б.ТӨРБАТ**

ГИШҮҮД  **Б.БИЛЭГДЭМБЭРЭЛ**

.....  **А.МОЛОР**

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Насангийн
ТУУЛ

1967 онд төрсөн. Түүхч-түүхийн багш, эрх зүйч, төрийн удирдлагын менежер мэргэжилтэй. Төрийн удирдлагын магистр.

1991-1995 онуудад Нийслэлийн 15-дугаар сургуульд Түүх-нийгмийн ухааны багш, 1996-1997 онд "Толь" сонины газар борлуулалт хариуцсан ажилтан, 1998-2000 онд Нийслэлийн Архивын газар сан хөмрөгийн эрхлэгч, Ахлах мэргэжилтэн, 2000-2006 онд Үндэсний Архивын газар Тамгын хэлтсийн дарга, Архив албан хэрэг хөтлөлтийн улсын ахлах байцаагч, 2006-2015 онд Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод хяналтын албаны мэргэжилтэн, албаны дарга, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, 2016-2018 онд Төрийн банкны Сүхбаатар дүүргийн салбарын захирал, 2018-2019 онд Эрдэнэс таван толгой ХК Хуульч, ахлах хуульч, хэлтсийн дарга, 2019-2020 онд Эрдэнэс таван толгой майнинг ХХК эрх зүйн хэлтэс, Хуульч, Хэлтсийн менежер, 2020-2025 онд Нийслэлийн архивын газар, Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, газрын даргаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан. Төрийн жинхэнэ албан хаагч эрхэлсэн түшмэл, тэргүүн зэрэгтэй. 2025 оны 4 сараас МЦХ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байгаа.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ Н.ТУУЛЫН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНАЛ


Н.Туул миний бие "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн хараат бус гишүүнээр 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс сонгогдон ажиллаж байгаа бөгөөд цаашид үргэлжлүүлэн ажиллах тохиолдолд хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй компанийн үйл ажиллагаанд хамаарах Компанийн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, компанийн засаглал, ашигт ажиллагаа, нэмэлт хувьцаа гаргах, Төлөөлөн удирдах зөвлөл,* Компанийн гүйцэтгэх удирдлагаас гаргах шийдвэр, үйл ажиллагаанд хараат бус шийдвэр гарган оролцоно.

Харилцаа холбооны салбар маш хурдацтай хөгжиж, шинэ технологиуд нэвтрэн байгаа үед ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн байгууллагууд ч өдөр тутам техник технологидоо шинэчлэл хийж байна.

Монгол Улсын Засгийн газраас "Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлснээр "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн энгийн хувьцааны 49 хүртэлх хувийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй арилжих бөгөөд төрийн эзэмшил 51 хувиас багагүй. байхаар төсөлд тусгасан байна. Энэ шийдвэр хэрэгжсэнээр Мэдээлэл харилцаа холбооны салбарт өрсөлдөхүйц хөрөнгө оруулагч орж ирэх боломжтой гэж үзэж байна.

Одоогийн байдлаар компани хэрэглэгчдийн тоогоо нэмэгдүүлэх, хуримтлагдсан өр төлбөрийн асуудлыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, найдваргүй өр төлбөрийг хэрхэх талаар шийдвэр гаргуулах, ажилтнуудын цалин хөлсийг салбарын хэмжээнд хүргэх, үүний тулд бүтэц зохион байгуулалтдаа дүн шинжилгээ хийж шинэчлэх зэргээр компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хараат бус гишүүний хувьд компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар хяналт тавих, ТУЗ-ийн бодлого, шийдвэр, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавьж, шаардлагатай асуудлаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч стратеги, бодлого, хариуцлагын асуудлаар хараат бус дүгнэлт гарган ТУЗ, түүний дэргэдэх хороод, Хувьцаа эзэмшигчдийн хуралд тогтмол биечлэн оролцож, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаална.



**Содномдаагийн
ЦОЛМОН**

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн багш

1983 онд Өвөрхангай аймагт төрсөн. Санхүүгийн удирдлагын бакалавр, бизнесийн удирдлагын магистр, доктор зэрэгтэй, боловсролын байгууллагад 15 жил ажилласан ажлын туршлагатай, 2008-2019 онд Номин холдинг, Бодлого зохицуулалтын газар, Төслийн менежер, 2019-2020 онд МУИС, Эдийн засгийн сургууль, Санхүүгийн тэнхим, багш, 2011-2021 онд Мандах их сургууль, Эдийн засаг бизнесийн тэнхим, багш одоо Мандах Их Сургуулийн Ахисан түвшний сургуулийн багш. Монгол Улсын Менежментийн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн; Доктор (Ph.D), профессор; Дотоод аудитор; Мэргэшсэн хөрөнгө оруулалтын зөвлөх. 2023 оноос Шивээ овоо ХК-ийн хараат бус гишүүн, МЦХ ХК-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байгаа.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ С.ЦОЛМОНГИЙН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНАЛ

Миний бие “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн ТУЗ-ийн Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүний чиг үүрэг болох хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийн үйл ажиллагааг хариуцлагатай, тогтвортой явуулахад нь чиглэгдсэн дараах ажлуудыг үе шаттайгаар төлөвлөн гүйцэтгэх боломжтой. Үүнд:

№	Ажлын төлөвлөгөө	Тайлбар
1	Компанийн үйл ажиллагаа, бизнесийн загвар, стратегийн зорилтуудыг хөгжүүлэх	Стратегийн төлөвлөгөө, эрсдэлийн төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө зэрэг төлөвлөлтүүд нь компанийн бизнес загвартайгаар хэрхэн уялдаж байгаад хяналт, дүн шинжилгээ хийх замаар сайжруулах санал өгнө
2	ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудтай тогтмол харилцаа холбоотой байх	Гүйцэтгэх захирал болон бусад удирдлагуудтай тогтмол уулзалт хийх, мэдээлэл солилцох замаар компанийн гүйцэтгэл, эрсдэл, боломжуудыг үнэлэх
3	ТУЗ-ийн болон бусад шаардлагатай хурлуудад тогтмол оролцох	ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд холбогдох хурлуудад шинэлэг санаачлаг гаргах, санал бодлоо бусадтай хуваалцах зэргээр тогтмол оролцоно
4	ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцож байх	ТЭЗ-ийн дэргэдэх хороод, тэр дундаа аудит, засаглал, эрсдэлийн хороодоос хийх хяналт, үнэлгээ, аудит болон судалгааны ажлууд дээр хамтран ажиллах
5	Компанийн гүйцэтгэлийг хянах, илэрсэн зөрчлийн бууруулахтай холбоотой зөвлөмж, зөвлөгөө өгөх	Эдийн засгийн болон салбарын өөрчлөл, компанийн өрсөлдөх чадвар, эрсдэл, боломжуудыг тодорхойлох зорилгоор санхүүгийн болон бусад үйл ажиллагааны гүйцэтгэлийг тогтмол хянаж, зөвлөмж өгч байх
6	Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангаж буйд хяналт тавин ажиллана	Компанийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, татварын багц хууль болон бусад холбогдох хууль, стандарт, эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлж байгаа эсэхэд нь тогтмол хяналт тавин ажиллана

6	Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангаж буйд хяналт тавин ажиллана	Компанийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, татварын багц хууль болон бусад холбогдох хууль, стандарт, эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлж байгаа эсэхэд нь тогтмол хяналт тавин ажиллана
7	Компанийн удирдлага, зарим алба нэгжүүдэд зориулсан мэргэжлийн сургалт, судалгаа болон хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж байх	Засаглал, бизнесийн удирдлага, тэр дундаа санхүү, эрсдэлийн чиглэлээр орчин үеийн онолын мэдлэг, гаднын сайн туршлагыг шингээсэн агуулга бүхий сургалтуудыг заах, шаардагатай төсөл, судалгааны ажлууд дээр зөвлөгөө өгөх, чиглүүлэх ажлууд хийнэ
8	Мэдээллийн аюулгүй байдал, нээлттэй, ил тод байдал болон бусад хяналтуудыг хийж байх	Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн бүрэн бүтэн байдал, эрсдэлийн менежментийн систем нь бат бөх, хамгаалагдсан эсэхийг хянах
9	Стратеги бодлого төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч байх	Компанийн үйл ажиллагааны стратеги, бодлого, гүйцэтгэл, хариуцлагын асуудлаар хараат бус шүүмж, дүгнэлтийг мэргэжлийн түвшинд өгөх
10	Компанийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд нь хамтран ажиллах	Мөнгөн хөрөнгө болон бусад нөөцийг оновчтой удирдаж; орлого, зардал болон ашгийн удирдлага зохистой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх замаар компанийн санхүүгийн чадавхыг сайжруулахад нь тогтмол хувь нэмрээ оруулж байх

Мөн миний бие нь танай компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллах хугацаандаа Компанийн компанийн тухай хууль болон засаглалын кодексд заасан бусад чиг үүргийн дагуу ажиллах болно. Ажиллах хугацаандаа аливаа шийдвэрийг хараат бусаар гаргах; ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөх; аливааг шинээр эрэлхийлж байх; аливаа асуудалд бүрэн мэдээлэл, баримтад тулгуурлан, дүн шинжилгээтэйгээр хянамгай хандаж байх; компанийн стратеги төлөвлөлт болон хэрэгжилтэд нь хувь нэмрээ оруулж байхаас гадна компанийн засаглалын цаашдын хөгжилд өөрийн туршлага, мэдлэгээ зориулан ажиллах болно.

Харилцаа холбооны салбарын хөгжлийн чиг хандлага, компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаарх санал

Хүн төрөлхтний түүхийн хуудсанд тодоор бичигдэн үлдсэн аж үйлдвэрлэлийн гурван том хувьсал нь бидний нийгэм, эдийн засагт асар том өөрчлөлт, боломжуудыг бий болгосон бол 21-р зууны эхэнд бид хиймэл оюун ухаан (AI), юмсын интернэт (IoT), тав жи (5G), үүлэн тооцоолол, блокчэйн тэргүүтэй дижитал технологид суурилсан аж үйлдвэрийн 4-р хувьсгалыг эхлүүлээд байна. Дижитал шилжилтийг хөгжлийнхөө гол үндсэн чиглэлээ болгож чадсан улс орнууд нь цаашид илүү өндөр хөгжих боломжтой гэж Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын судалгаанд дурджээ. Харилцаа холбооны салбар нь сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж, өөрчлөгдөж байгаа бөгөөд дээрх технологиуд нь тус салбарын хөгжлийг тодорхойлогч гол чиглэл нь болжээ. Үүнд:

- **5G технологи:** 5G технологи гарч ирснээр харилцаа холбооны салбарт ихээхэн хувьсгал хийхээр хүлээлттэй байна. Учир нь илүү хурдтай, хоцрогдол багатай 5G сүлжээнүүд нь виртуал бодит байдал, бие даасан тээврийн хэрэгсэл, ухаалаг хот зэрэг олон төрлийн шинэ программ, үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой юм.

- **Юмсын интернэт (IoT):** Тус технологи нь мэдээллийг солилцох, машин болон объектуудын харилцан уялдаатай систем юм. IoT нь харилцаа холбооны салбарт мөн л ихээхэн өөрчлөлт, шинэчлэлтийг авчрах хүлээлттэй байгаа ба 2025 он гэхэд олон тэрбум тооны төхөөрөмжүүд холбогдон ашиглагдах төлөвтэй байна.

- **Хиймэл оюун ухаан (AI):** Өдгөө харилцаа холбооны салбарт хиймэл оюун ухааны хэрэглээ хурдацтай нэмэгдэж байна. Хиймэл оюун ухаан нь их хэмжээний өгөгдөлд шинжилгээ хийх, үйл явцыг автоматжуулах, сүлжээний гүйцэтгэлийг сайжруулах гэх мэтээр харилцаа холбооны салбарт олон чиглэлээр ашиглах боломжтой.

Үүлэн тооцоолол:

Үүлэн тооцоолол нь харилцаа холбооны салбарыг өөрчилж, үйлчилгээ үзүүлэгчдэд төлбөр төлж, үнэтэй техник хангамж, дэд бүтцийн хэрэглээг бууруулах зэргээр илүү их үр ашиг би болгох боломжтой.

- Үүлэн тооцоолол: Үүлэн тооцоолол нь харилцаа холбооны салбарыг өөрчилж, үйлчилгээ үзүүлэгчдэд төлбөр төлж, үнэтэй техник хангамж, дэд бүтцийн хэрэглээг бууруулах зэргээр илүү их үр ашиг би болгох боломжтой.
- Виртуалчлал: Виртуалчлал нь алсаас удирдаж, тохируулах боломжтой виртуал сүлжээ, үйлчилгээг бий болгох боломжийг олгодог. Энэ нь зардлыг бууруулах, уян хатан байдлыг нэмэгдүүлэх, сүлжээний гүйцэтгэлийг сайжруулахад тусална.
- Кибер аюулгүй байдал: Харилцаа холбооны салбар нь технологи, өгөгдөлд илүү хамааралтай болохын хэрээр кибер аюулгүй байдал нь чухал асуудал болж байна.

Өөрөөр хэлбэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн чиг хандлага нь хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд суурилсан технологийн дэвшил, дижиталчлал бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх чиглэл рүү явж байна. Эдгээр чиг хандлагад дасан зохицож, шинэлэг шийдлүүдийг санал болгох замаар өрсөлдөх чадвар болон ашиг орлогоо нэмэгдүүлэх нь тус салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын гол сорилт болж байна.

Иймд харилцаа холбооны салбарын компани, тэр дундаа “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ны хувьд эдийн засгийн үр ашгаа дээшлүүлэхийн тулд дараах бодлого, стратегиудыг хэрэгжүүлэх нь зохистой гэж үзэж байна. Үүнд:

1. Шинэ технологид хөрөнгө оруулалт хийх: Харилцаа холбооны компаниуд нь өрсөлдөх чадвартай байхын тулд шинэ технологид байнга хөрөнгө оруулалт хийх. Өөрөөр хэлбэл, шинэлэг технологи болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, сүлжээний дэд бүтцийг шинэчлэх, автоматжуулалт, хиймэл оюун ухаан технологийг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулах нь зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд тус болно.
2. Үйл ажиллагааг оновчтой болгох: Үр ашиггүй зардлаа бууруулж, үйл явцыг илүү оновчлох, системийн болон процессын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг хослуулах замаар эдийн засгийн үр ашгаа дээшлүүлэх.
3. Хэрэглэгчийн хэрэгцээг тогтмол судлах: Хэрэглэгчийн сонирхол, эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжийг тогтмол судлах замаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ тасралтгүй хөгжүүлж, сайжруулах. Эдгээр стратегийг хэрэгжүүлснээр харилцаа холбооны салбарын компаниуд эдийн засгийн үр ашгаа дээшлүүлж, зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.



1961 онд Баян-Өлгий аймагт төрсөн. Эдийн засагч-нягтлан бодогч мэргэжилтэй, эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй. Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч, Монгол улсын мэргэшсэн үнэлгээчин, Аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламжийг тус тус авсан.

1984-1990 онд ХААЯ-ны Санхүү бүртгэлийн хэлтэст мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны дээд зөвлөлийн санхүү, бүртгэлийн хэлтэст мэргэжилтнээр, 1990-2003 онд Түшиг даатгал компани, Ерөнхий нягтлан бодогч, Гүйцэтгэх захирал, 2003-2008 онд Итгэлт-Аудит компани, Дэд захирал, 2008 оноос “Акпар-Аудит” компанийн Ерөнхий захирлаар ажиллаж байна. 2018-2023 онд Багануур АЗЗА, Дундговь АЗЗА хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байсан. 2023 оноос МЦХ ХК-ийн ТУЗ-ийн хараат гишүүнээр ажиллаж байгаа.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ Х.БАЯНБАЙГИЙН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНАЛ

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хараат бус гишүүнээр сонгогдсон нөхцөлд Дотоод аудитортай хамтран Үл хөдлөх хөрөнгө, газрын бүртгэл болон авлагын бүртгэлд дүн шинжилгээ хийж үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, найдваргүй авлагыг данснаас хасуулах талаар санал боловсруулж ТУЗ-ийн хуралд оруулан шийдвэр гаргуулна.



**Найдангийн
ДАНЗАНДАГВА**

“Голомт капитал” ҮЦК-ийн
Арилжааны газрын захирал

1986 онд төрсөн. Эдийн засагч мэргэжилтэй. Олон улсын бизнесийн магистр зэргийг БНХАУ-д хамгаалсан.

2008-2010 онд Санхүүгийн зах зээлийн холбоонд аналит, 2013-2014 онд Хас банкны Эрсдэлийн газарт Эрсдэлийн шинжээч, 2014-2020 онд Хөгжлийн банкинд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, Санхүү удирдлагын албаны дарга, хэлтсийн дарга, 2020-2021 онд Тээвэр хөгжлийн банкны Хятад хамтын ажиллагааны газрын захирлаар ажиллаж байсан. 2021 оноос Голомт капитал ҮЦК-ийн Арилжааны газрын захирлаар ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, уул уурхайн брокер.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ Н.ДАНЗАНДАГВЫН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНАЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн ажлын төлөвлөгөө

Энэхүү танилцуулж буй төлөвлөгөө нь сонгон шалгаруулалтыг зарлаж буй байгууллагын дунд, урт хугацааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, ТУЗ-ийн гишүүний хувиар байгууллагад засаглал, зах зээлд эзлэх байр суур, санхүүгийн тогтвортой өсөлтийг бий болгоход хувь нэмрээ оруулж ажиллана.

ТУЗ-ийн гишүүнээр ажиллах ажлын төлөвлөгөөгөө дараах үе шатанд хуваан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1. Компанитай танилцах үе шат:


- ТУЗ-ийн дүрэм, компанийн засаглалын бодлоготой танилцах;
- Компанийн нөхцөл байдлыг судлах хүрээнд санхүүгийн тайлан, стратеги төлөвлөгөөтэй танилцах, дүгнэлт хийх, дунд болон урт хугацааны төлөвлөгөөний суурь нөхцөлийг боловсруулах;
- Компанийн Удирдлагын баг, хүний нөөцтэй танилцаж, одоогийн нөхцөл байдалд шинжилгээ хийх.

2. Үйл ажиллагааны үе шат

- Тогтмол оролцоо: Хуралдаанд бэлэн, идэвхтэй оролцох.
- Стратеги тодорхойлох: Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд бодитой хувь нэмэр оруулах.
- Санхүү, гүйцэтгэлийг хянах: Тайлангуудыг нягталж, хяналт тавих.
- Эрсдэлийн менежмент: Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, удирдах.
- Ёс зүй, хариуцлага: ТУЗ-ийн сайн засаглалыг баримтлах.

3. Компанийн дунд, урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө боловсруулах:

- Салбарын нөхцөл байдлыг судлах, ижил төстэй үйл ажиллагаатай ААН-үүдийг судлах.
- Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх шинэ арга замуудыг эрэлхийлэх.
- Жил бүр өөрийн гүйцэтгэлээ үнэлж, сайжруулах боломжуудыг тодорхойлох.



Санхүүгийн СОЛОНГО

Хөдөлмөр хамгаалал, хүний
хөгжлийн төв ТББ-ын
Гүйцэтгэх захирал

1973 онд төрсөн. Цахилгааны инженер, Нягтлан бодогч, Хянан шалгагч, багш, сургуулийн өмнөх боловсрол мэргэжилтэй.

2000-2010 онд Хөдөлмөр хамгаалал, хүний хөгжлийн төв ТББ-д менежер, Гүйцэтгэх захирал, 2010-2021 онд Монгол ардын намын Удирдах зөвлөл, Сан хөрөнгийн хэлтсийн нягтлан бодогч, 2021-2023 онд Тавантолгой төмөр зам ХХК, Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч, 2023-2024 онд “Автозамын засвар, арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн Ерөнхий нягтлан бодогч, 2025 онд “Хилийн боомтын захиргаа”, Хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын албанд Санхүүгийн аудитор, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн, 2026 оноос Хөдөлмөр хамгаалал, хүний хөгжлийн төв ТББ Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

2019-2021 онд “ДЦС-3” ТӨХК, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, 2021-2022 онд “Амгалан” ДЦС ТӨХК Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажилласан туршлагатай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ С.СОЛОНГОГИЙН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНАЛ

Монголын цахилгаан холбоо ХК нь харилцаа холбооны салбарын технологийн хурдацтай хөгжил, зах зээлийн өрсөлдөөний эрчимжилт, төрийн өмчит компанийн засаглалын шинэчлэлийн шаардлагын огтлолцолд үйл ажиллагаа явуулж байна. Харилцаа холбооны салбар нь уламжлалт үйлчилгээ давамгайлсан бүтцээс дата, дижитал, платформд суурилсан зах зээл рүү эрчимтэй шилжиж байгаа нь компанийн стратеги, үйл ажиллагаанд бодит өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Ийм нөхцөлд компанийн урт хугацааны тогтвортой хөгжил нь засаглалын чанар, дотоод хяналтын үр нөлөө, эрсдэлийн удирдлагын тогтолцооноос шууд хамаарах тул эдгээр чиглэлд бодлогын түвшний шинэчлэл хийх шаардлагатай байна. Гол сорилтууд:

- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хяналт, хариуцлагын заагийг тодорхой болгох шаардлага
- Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг бэхжүүлэх
- Санхүүгийн сахилга бат, зардлын үр ашгийг нэмэгдүүлэх
- Хөрөнгө оруулалтын шийдвэрийн өгөөж, үр нөлөөг сайжруулах
- Ил тод байдал, хариуцлагын шаардлагыг шинэ түвшинд хүргэх

Хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ:

Миний бие өөрийн мэргэжлийн хүрээнд компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэхэд чиглэн дараах ажлуудыг хэрэгжүүлэхийг зорьж байна. Үүнд:

- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, хараат бус хяналтын тогтолцоог бодитоор хэрэгжүүлэх
- Эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөлт, хэрэгжилтийг нэвтрүүлж, аудитын хараат бус байдлыг хангах

- Санхүүгийн сахилга бат, зардлын хяналтыг сайжруулж, үр ашиггүй зардлыг бууруулах, худалдан авалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх

- Хөрөнгө оруулалт, томоохон төсөлд өгөөжид суурилсан (POI, NPV) үнэлгээ, ТУЗ-ийн түвшний хяналтыг хэрэгжүүлэх

- Ил тод тайлагнал, ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх

Хүлээгдэж буй үр дүн:

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр компанийн засаглал, хяналтын тогтолцоо бодитоор сайжирч, санхүүгийн сахилга бат, үр ашиг нэмэгдэн, эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулалтын өгөөж дээшлэх, улмаар компанийн өрсөлдөх чадвар, нэр хүнд, тогтвортой хөгжил хангагдана.

Дүгнэлт:

Миний бие санхүү, аудит, хяналтын чиглэлээр хуримтлуулсан олон жилийн туршлагадаа тулгуурлан компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж, ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийг мэргэжлийн, хараат бус зарчмаар хэрэгжүүлэн ажиллах болно.

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД




Цэнддаваагийн БАЯР-ЭРДЭНЭ

ТӨБЗГ-ын зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн дарга

1979 онд Төв аймагт төрсөн. МУИС-ийг Улс төр судлаач-нийгмийн ухааны багш, АНУ-ын Страйерын их сургууль төрийн удирдлагын менежер мэргэжлээр тус тус төгссөн.

2001-2006 онд МАН-ын сургалт судалгааны хэлтэс, Прогноз төв, эрдэм шинжилгээний ажилтан, 2006-2008 онд МАН-ын сургалт судалгааны хэлтэс, Прогноз төв, дарга, албаны дарга, 2008-2011 онд Нийслэлийн МАН-ын хороо, зохион байгуулалтын хэлтсийн дарга, 2008-2011 онд Нийслэлийн ИТХ дахь МАН-ын бүлгийн ажлын албаны дарга, 2015-2016 онд МАН, МАН-ын ерөнхий нарийн бичгийн даргын орон тооны зөвлөх, 2016.09 одоог хүртэл ТӨБЗГ, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс болон Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн даргаар ажиллаж байна. 2016-2020 онд МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн даргаар, 2019-2020 онд Эрдэнэс таван толгой ТӨХК-ийн гишүүнээр тус тус ажиллаж байсан.



Аминдаваагийн МОЛОР

ТӨБ зохицуулалтын газар,
Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтэс,
мэргэжилтэн

1990 онд Улаанбаатар хотод төрсөн. Шинжлэх ухаан технологийн их сургуулийг Механик инженерийн бакалавр мэргэжлээр төгссөн. 2013-2015 онд Күүл дизайн ХХК, Захирал, дизайнер, 2015-2019 онд Нэйшнл трейдинг энд транспорт групп ХХК, дэд захирал, 2020 онд Виннин магнитюд ХХК, Захирал, контент бүтээгч, 2021 оноос Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Мэдээлэл технологийн алба, Мэдээлэл технологийн ажилтан, (2021 оны 9 сар) Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс, Удирдлага, төлөөллийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна. 2022-2023.5.01 онд Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан, 2021 оноос Увс АЗЗА, Ховд АЗЗА, Завхан АЗЗА, Говь-Алтай АЗЗА ТӨХК-иудын дундын ТУЗ-д ердийн гишүүн, 2022 оноос МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа.



1978 онд Улаанбаатар хотод төрсөн. Шинжлэх ухаан технологийн их сургуулийг Мэдээллийн технологи, Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын мэргэжлээр тус тус төгссөн. 2001-2009 онд Иргэний бүртгэлийн улсын төвд Программ зохиогч, Мэдээллийн сангийн зохицуулагч, 2014 онд Улсын бүртгэлийн ерөнхий газар Мэдээллийн технологийн газрын дарга, 2014.9-2016 онд Хууль зүйн яамны Цахим нэгтгэлийн төслийн нэгжийн зохицуулагч, 2016.9-2022 онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, Цахим хөгжлийн газрын мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дарга, 2022-2024 онд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, 2024-2025 онд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Цахим засаглал, мэдээллийн технологийн газрын дарга, 2025 оноос Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Системийн шинжилгээ, мэдээллийн технологийн газрын даргаар ажиллаж байна. 2024 оноос МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа.



1985 онд Завхан аймагт төрсөн. ИЗИС-ийг Эрх зүйч, Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежер, “Их засаг” олон улсын их сургуулийг Эрх зүйн магистр мэргэжлээр тус тус төгссөн. 2009-2022 онд Оюуны өмчийн газар улсын байцаагч, Хүний нөөц, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, 2022 онд ЦХХХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, 2023-2024 оноос Салбарын хяналтын газрын дарга, 2024 оноос Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Зөвлөхөөр ажиллаж байна. 2024 оноос МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа.



Даваахүүгийн НАРАНГЭРЭЛ

ТӨБ зохицуулалтын газрын
Төрийн өмчийн бүртгэл,
ашиглалтын хэлтсийн дарга,
Мэргэшсэн нягтлан бодогч

1971 онд Говь-Алтай аймагт төрсөн. ОХУ-ын Иваново хотын Их сургуулийг физик, математикийн магистр, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг Бизнес удирдлагын бакалавр /санхүү, нягтлан бодох бүртгэл/ мэргэжлээр төгссөн. ОХУ-ын Иваново хотын Их сургуульд Орос хэл заах арга зүй/багшлах, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт Мэргэшсэн нягтлан бодогч (хугацаагүй эрхтэй) тус тус мэргэжил дээшлүүлсэн. 1990-1996 онд Хийморь хэвлэлийн газар ажилтан, 1996.12-2016.8 онд Төрийн өмчийн хороонд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, албаны дарга, 2016.2-2016.8 онд Сангийн яам, Хэлтсийн дарга, 2016 оноос Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн даргаар ажиллаж байна. 2024 оноос МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа.



Бат-Эрдэмийн ТӨРБАТ

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар, шинжээч

1991 онд Сэлэнгэ аймагт төрсөн. МУИС-ийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2013-2016 онд Монголын хуульчдын холбоонд Туслах, мэргэжилтэн, 2016 оноос одоог хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар шинжээчээр ажиллаж байна. 2023 оноос МЦХ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа.

ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ

/Нэгж: төгрөг/

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1. Цалингийн зардал					
1	ТУЗ-ийн дарга	1	1,400,000	12	16,800,000
2	ТУЗ-ийн хараат бус гишүүн	3	1,320,000	12	47,520,000
3	ТУЗ-ийн ердийн гишүүний цалин	5	1,200,000	12	72,000,000
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	1,200,000	12	14,400,000
Цалингийн зардлын дүн					150,720,000
5	Нийгмийн даатгалын шимтгэл				20,045,760
Дэд дүн					170,765,760
2. Бичиг хэрэг, хурал, холбоо, тээврийн зардал					
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	180,000	12	2,160,000
2	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	180,000	12	2,160,000
4	Бусад зардал	1	100,000	5	500,000
Дэд дүн					5,220,000
3. Сургалт, компанийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах зардал					
1	Сургалт, семинарын зардал				8,500,000
2	Томилолтын зардал				10,000,000
Дэд дүн					18,500,000
НИЙТ ДҮН					194,485,760

Тайлбар: Төсөв 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа (2027) оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 дүгээр сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14, 96.5 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

ГБОЛДСАЙХАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 дүгээр сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ ЧӨЛӨӨЛЖ, СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгосугай.

2. нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

ГБОЛДСАЙХАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 дүгээр сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.БОЛДСАЙХАН



TV ROOM
ТАВТАЙ МОРИЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
220 дугаар хурлын 02 дугаар тогтоолын Гурвалдугаар хэсэгт.



САНАЛЫН ХУУДАСНЫ АГУУЛГА, ЗАГВАР

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерын овог нэр

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт болно.

Д/д	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдолд өгөх санал
1.	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай				
2.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай				

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг	Улсын бүртгэлийн дугаар
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал
Регистрийн дугаар:	Гарын үсэг:
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг	

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
220 дугаар хурлын 02 дугаар тогтоолын Дөрөвдүгээр хавсралаар.



ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОХ САНАЛЫН ХУУДАСНЫ АГУУЛГА, ЗАГВАР

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/

Брокерын овог нэр

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт болно.

Д/д	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
	Ердийн гишүүд	
1		
2		
3		
4		
5		
6		
	Хараат бус гишүүд	
1		
2		
3		
4		
5		
6		

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг	Улсын бүртгэлийн дугаар
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал
Регистрийн дугаар:	Гарын үсэг:
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг	



ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна. Кумулятив аргыг хэрэглэж сонгогдсон ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд үйлчлүүлж буй үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг утсаар лавлаж болно.
3. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) эсхүл (0) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) эсхүл (0), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (+) эсхүл (0), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) эсхүл (0) тэмдэг тавина.
4. Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа Татгалзсан тохиолдолд өгөх санал гэсэн баганад бичнэ үү
5. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн бол санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэрэв та Саналын хуудсыг буруу бөглөсөн бол санал өгч буй этгээд нь Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө Саналын хуудсыг дахин авч бөглөж болно.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ТЭМДЭГЛЭЛ

Blank area with horizontal dotted lines for notes.